



МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 4 сарын 28 өдөр

№ 23/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа” гэж 4.1.7 дахь заалтаар нэмж оруулсугай.
2. Энэ тогтоолын 1-т зааснаар шийдвэрлэсэнтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хорооноос хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, улсын бүртгэлд бүртгүүлэх болон бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ч.Хашчулуун)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА,



★★